**НИЙСЛЭЛИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

2023 оны 06 сарын 21 өдөр Дугаар 70 Улаанбаатар хот

Тооллогын нэгдсэн дүнг баталгаажуулах
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл, 77 дугаар зүйлийн 77.2.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай" 9 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн тооллогын нэгдсэн дүнг нийт 4,839,259,944,785.14 (дөрвөн их наяд найман зуун гучин есөн тэрбум хоёр зуун тавин есөн сая есөн зуун дөчин дөрвөн мянган долоон зуун наян таван төгрөг арван дөрвөн мөнгө) төгрөгөөр баталгаажуулж, хавсралтаар батлсугай.

2.Төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хандив тусламжаар шинээр бий болсон бүртгэлд тусгагдаагүй эд хөрөнгийг бүртгэх, тооллогоор илэрсэн зөрчил дутагдал, маргаантай асуудлыг шийдвэрлэх талаар тодорхой ажлыг зохион байгуулж, дүнг 2023 оны IV улиралд багтаан танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат) -нд даалгасугай.

ДАРГА Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 21-ний 70 дугаар тогтоолын хавсралт

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН НЭГДСЭН ДҮН

/мян.төг/

| Д/д | Дүүргийн нэрс | Хуулийн этгээдийн тоо | Балансын дүн | Элэгдлийн дүн | Үлдэгдэл өртөг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Багануур | 41 | 228,635,661.54 | 28,183,924.72 | 200,451,736.82 |
| 2 | Багахангай | 24 | 34,912,628.76 | 9,998,671.18 | 24,913,957.58 |
| 3 | Баянгол | 106 | 434,889,144.53 | 91,437,339.77 | 343,451,804.77 |
| 4 | Баянзүрх | 154 | 1,348,842,624.5 | 269,528,998.39 | 1,079,313,626.11 |
| 5 | Налайх | 45 | 176,365,956.65 | 28,281,716.35 | 148,084,240.29 |
| 6 | Сонгинохайрхан | 149 | 628,115,688.11 | 105,141,694.83 | 522,973,993.28 |
| 7 | Сүхбаатар | 115 | 617,037,666.33 | 157,763,725.89 | 459,273,940.44 |
| 8 | Хан-Уул | 103 | 513,818,900.96 | 176,794,095.49 | 337,024,805.47 |
| 9 | Чингэлтэй | 132 | 856,641,673.4 | 233,772,992.53 | 622,868,680.88 |
| | **Нийт** | 869 | **4,839,259,944.79** | 1,100,903,159.14 | 3,738,356,785.64 |